

## **Улсын оюутны программчлалын XXXIV олимпиад зохион байгуулах тухай**

Улсын Программчлалын 34 дүгээр олимпиадыг 2026 оны 05 дугаар сарын 08-наас 10-ы өдрүүдэд МУБИС-ийн Математик, Байгалийн Ухааны сургуулийн Мэдээлэл зүйн тэнхим зохион байгуулна.

Олимпиадад программчлал, мэдээллийн технологийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг их сургууль бүрээс нэг үндсэн баг оролцох ба нэмэлтээр нэг баг оролцуулж болно. Баг нь гурван оюутан, нэг дасгалжуулагч багштай байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг [www.informatics.edu.mn](http://www.informatics.edu.mn) цахим хуудас, программчлалын олимпиад зохион байгуулах комиссын 99003771 утсаар авна уу. Олимпиадад холбогдох мэдээллийг хавсаргав.

**МОНГОЛЫН МЭДЭЭЛЭЛ ЗҮЙН БОЛОВСРОЛЫН ТООЦООЛОЛ НИЙГЭМЛЭГ НҮТББ-ЫН**

**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ..... ДОКТОР, ПРОФЕССОР Д.ЦЭДЭВСҮРЭН**

## ОЮУТНЫ ПРОГРАММЧЛАЛЫН УЛСЫН ХХХIV ОЛИМПИАД ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

### 1. Ерөнхий зүйл

- 1.1. Программчлалын олимпиадыг 2026 оны 5-р сарын 08-аас 10-ны өдрүүдэд МУБИС-ийн Математик, Байгалийн Ухааны сургуулийн Мэдээлэл зүйн тэнхим дээр зохион байгуулна.
- 1.2. Сургууль бүрийн олимпиадад оролцох баг нь 3 оюутан, удирдан оролцуулах багштай байна.
- 1.3. Багийн бүрэлдэхүүнд оролцох оюутан нь тухайн сургуулийн үндсэн оюутан байх ба одоогоор сураагүй, чөлөө авсан болон сургуулиас гарсан оюутныг оролцуулж болохгүй. Хэрэв оролцсон нь батлагдвал багийн нийт оноог хүчингүйд тооцно.
- 1.4. Олимпиадад мэдээллийн технологи, программ хангамжийн мэргэжлээр их дээд сургуулийн оюутнууд хоёр өдрийн турш 6 (нэг өдөр 3 бодлого) бодлого бодож өрсөлдөнө.

### Хоёр. Зохион байгуулалт

- 2.1. Олимпиадад сургууль бүрээс 3 оюутан, 1 дасгалжуулагч багш бүхий нэг баг оролцоно.
- 2.2. Нэмэлт нэг баг байж болох ба мөн 3 гишүүнтэй байна.
- 2.3. Багийн мэдүүлгээ 2026 оны 05 дүгээр сарын 05 хүртэл бүртгэх ба багийн мэдүүлгийн албан бичгийн цахим хуулбарыг [battogtokh@msue.edu.mn](mailto:battogtokh@msue.edu.mn) хаяг руу явуулах ба техникийн зөвлөгөөнд ирэхдээ цаасаар авчирч өгнө. Мэдүүлэгт:

- Багийн гишүүдийн болон багийн дасгалжуулагч багшийн мэдээлэл байна.

#### А. Багийн гишүүдийн мэдүүлэг

Багийн нэр: \_\_\_\_\_

№	Овог	Нэр	РД	Тухайн сургуульд элссэн он	Одоо суралцаж байгаа мэргэжил курс	Утас	Ямар хэл дээр программ бичих
1.							
2.							
3.							

#### Б. Багийн дасгалжуулагчийн мэдүүлэг

№	Овог	Нэр	Сургууль, тэнхим	Албан тушаал, цол, зэрэг	Утас	Э-мэйл хаяг
1.						

- 2.4. Олимпиадыг олон улсын мэдээлэл зүйн олимпиадын автомат системээр явуулна.
- 2.5. Техникийн зөвлөгөөн болон практик уралдаан 2026 оны 05-р сарын 08-ы өдрийн 16:00 цагт МУБИС-ийн Мэдээлэл зүйн тэнхим (МУБИС-ийн хичээлийн 12 дугаар байрны 6 давхарт) дээр болно. Оролцох сургууль бүрээс нэг төлөөлөл заавал оролцоно.
- 2.6. Үндсэн баг-300,000 төгрөг Нэмэлт баг-1,200,000 төгрөг. Хураамжийг бүртгүүлэхдээ бэлнээр эсвэл Мэдээлэл зүйн боловсролын тооцоолол нийгэмлэг НҮТББ (Монголын Мэдээлэл зүйн олимпиадын хороо, ММЗОХ)-ын дансанд /Данс: ХААН банкны 5431489471, Байгууллагын РД: 6838022 / тушааж баримтыг авчирна. Цахим нэхэмжлэх авах бол Д.Цэдэвсүрэн (99082681, [tsedevsuren@msue.edu.mn](mailto:tsedevsuren@msue.edu.mn)) холбогдоно уу.

2.7. Бодлого сонгох комиссыг олимпиадад оролцож буй их сургуулийн багш нарын төлөөллөөс оролцуулан ММЗОХ байгуулах ба уг комисс нь дэвшигдсэн бодлогоос хэлэлцэн сонгоно.

2.7. Оролцогч сургуулиуд бодлого дэвшүүлэх ба бодлогын нууцлалыг хангах үүрэгтэй. Хэрэв бодлого задарсан нь тогтоогдвол тухайн сургуулийн багийн бүх гишүүдийн оноог хүчингүйд тооцно.

### **Гурав. Шагнал урамшуулал**

3.1. Оролцогч оюутнууд хувийн амжилтаар өрсөлдөнө. :

- I байр 1 оюутан, Алтан медаль, диплом, мөнгөн шагнал
- II байр 2 оюутан, Мөнгөн медаль, диплом, мөнгөн шагнал
- III байр 3 оюутан, Хүрэл медаль, диплом, мөнгөн шагнал

3.2. Оролцсон багуудыг гишүүдийн амжилтаар буюу тухайн багийн гишүүдийн авсан нийт оноогоор байр эзлүүлэн сургуульд батламж гардуулна.

- I байр 1 баг, диплом
- II байр 1 баг, диплом
- III байр 1 баг, диплом

### **Дөрөв. Олимпиадад дэвшүүлэх бодлогод тавих шаардлага**

4.1. Олимпиадад мэдээллийн технологийн чиглэлийн их дээд сургуулийн багш, программчлалын мэргэжилтнүүд бодлого дэвшүүлнэ.

4.2. Бодлого /өгүүлбэр, тест, программын код/-ыг нууц үгтэйгээр багцлан тухайн өдрийн өглөө 08:00 цагт [ulambayar@msue.edu.mn](mailto:ulambayar@msue.edu.mn) /Лавлах утас: 99044079/ хаягаар ирүүлсэн байна.

4.3. Бодлого сонгох өдрийн өглөө нууц үгийг сонгох комиссын гишүүн холбоо барьж авах тул бодлого дэвшүүлэгч нь бодлого сонгох өдрийн 08:00-10:00 цагийн хооронд утсаа нээлттэй байлгах үүрэгтэй.

4.4. Бодлогын өгүүлбэр Монгол хэлээр ойлгомжтой тодорхой бичигдсэн байх ба хоёрдмол утга агуулаагүй тодорхой томъёологдсон байна.

4.6. Бодлого нь нэг хариутай эсвэл олон хариутай бол бодлогын зохиогч бодлогын чейкрийг ирүүлсэн байна.

4.7. Бодлогын оролтын файлуудыг input?.txt хэлбэрээр, гаралтын файлуудыг output?.txt гэж нэрлэсэн байна. Энд ?? нь 00, 01, 02, ..., 99 хүртэлх тоог төлөөлнө. Бодлогын тест 20-оос цөөнгүй, бодлогын онцгой болон хязгаарын тохиолдол бүрийг хангаж байхаар чанартай боловсруулагдсан байна.

4.8. Бодлогын өгүүлбэрт өгөгдлийн хязгаарлалтууд тодорхой, дэд бодлогуудад хуваагдсан байна. Дэд бодлого бүрийн оноо болон тестийн тоог тодорхой заасан байна.

4.9. Бодлогын тестийн форматыг өгүүлбэрт тодорхой заасан байх ба зохиогчийн тестийн файлууд нь уг форматыг зөрчөөгүй байна.

4.9. Бодлого нь иж бүрэн /өгүүлбэр, тест, программын код, чейкер/ бөгөөд бодлогын шалгуур үзүүлэлтийг хангасан үед бодлогын сонголтод оруулна.

## УЛСЫН ОЮУТНЫ ПРОГРАММЧЛАЛЫН ХХХІV ОЛИМПИАДЫН ХӨТӨЛБӨР

### 2026.05.08. Баасан гариг

- 16:00 Олимпиадын техникийн зөвлөгөөн /12-700 тоот өрөөнд/
- 17:00 Практик уралдаан, CMS-ийн туршилт /Оюутнууд, 12-702, 12-703 тоот өрөөнд/

### 2026.05.09 Бямба гариг

- 08:00 Бодлого сонгох, шалгах, серверт байрлуулах, зохион байгуулалтын ажлууд
- 10:00-11:00 Олимпиадын нээлтийн үйл ажиллагаа
- 11:30-15:30 Олимпиадын бодлого бодох /12-605, 12-702, 12-703 тоот лабораториудад/
- 16:30 Дүнгийн мэдээлэл ([www.informatics.edu.mn](http://www.informatics.edu.mn))

### 2026.05.10 Ням гариг

- 07:00 Бодлого сонгох, шалгах, серверт байрлуулах, зохион байгуулалтын ажлууд
- 09:00-13:00 Олимпиадын бодлого бодох /12-605, 12-702, 12-703 тоот лабораториудад/
- 14:00-15:00 Бодлогын анализ /12-700/
- 17:00 Олимпиадын дүнгийн хурал, шагнал гардуулах ёслол, дурсгалын зураг татуулах

**МУБИС-ийн МБУС-ийн Мэдээлэл зүйн тэнхим**

**Монголын Мэдээлэл зүйн боловсролын тооцоолол нийгэмлэг НҮТББ (Монголын  
Мэдээлэл зүйн олимпиадын хороо)**

## **АЛБАН БИЧИГ ЯВУУЛАХ СУРГУУЛИУД**

1. МУБИС-ийн Математик, Байгалийн ухааны сургууль
2. МУИС-ийн Мэдээллийн технологи, электроникийн сургууль
3. ШУТИС-ийн Мэдээлэл, холбооны технологийн сургууль
4. ХААИС-ийн Хэрэглээний шинжлэх ухааны сургууль, компьютерийн ухааны тэнхим
5. Санхүү эдийн засгийн их сургууль
6. Мандах их сургуулийн Мэдээлэл, технологийн сургууль
7. Шинэ Монгол технологийн дээд сургууль
8. ИЗИС-ийн Үндэсний инженер технологийн сургууль
9. Олон улсын Улаанбаатар их сургууль
10. Отгонтэнгэр их сургууль
11. Хүрээ мэдээлэл холбоо технологийн дээд сургууль